



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/513

Арвайхээр

Зардал хувиарлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн "Аймгийн 2021 оны төсөвт тодотгол хийх тухай" 05/07 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Аймгийн 2021 оны төсөвт тодотгол хийх тухай" аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05/07 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 2.3 дахь заалтад тусгагдсан зардлаас Арвайхээр сумын 212, 455 дугаар байруудын дээвэр, зарим хуучин орон сууцнуудын ус буулгагч болон гадна дулааны худагт ф50-100 мм хаалт солих зардалд 100,000,000 (нэг зуун сая) төгрөг, Арвайхээр сумын 25 айлын орон сууцны дээврийн засварын зардалд 30,000,000 (гучин сая) 803 дугаар байр 20 айлын орон сууцны дээврийн засварын зардалд 30,480,900 (гучин сая дөрвөн зуун наян мянга есөн зуу) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх хөтөлбөр арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (З.Балданям)-д даалгасугай.

3. Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101084